

**САНГИЙН САЙДЫН ДЭРГЭДЭХ
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН
ХОРООНЫ ТОГТООЛ**

2021 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр


№ 13

Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйл болон Сангийн сайдын 2016 оны 323 дугаар тушаалыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. УСНББОУС 41 “Санхүүгийн Хэрэглүүр”; УСНББОУС 42 “Нийгмийн халамжийн тэтгэмж”; 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд; 2019 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд; УСНББОУС 36 “Хараат байгууллага ба хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалт” болон УСНББОУС 41 “Санхүүгийн Хэрэглүүр”-ийн нэмэлт өөрчлөлт; УСНББОУС 19 “Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө”-ийн нэмэлт өөрчлөлтийн монгол орчуулгыг баталсугай.
2. Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын 2021 оны хэвлэлийн А хэсэг (Үндсэн стандартууд, Тайлбарууд, Нэр томъёоны тайлбар толь)-ийн монгол орчуулгыг бүрэн эхээр нь баталсугай.
3. УСНББОУС 2021 оны хэвлэл дэх шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон стандартуудын монгол орчуулгыг Сангийн яамны цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлэхийг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т даалгасугай.
4. Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын 2021 оны хэвлэлийн А хэсгийн монгол орчуулгыг олон нийтэд хүргэх арга хэмжээг 2021 оны 12 дугаар сард багтаан хэрэгжүүлж, үр дүнг танилцуулахыг ММНБ-ын Институт /М.Батхуяг/-д үүрэг болгосугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай.

САНГИЙН ДЭД САЙД БӨГӨӨД
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН
СТАНДАРТЫН ХОРООНЫ ДАРГА



С.МӨНГӨНЧИМЭГ